

КАМПУЧИ НИЙГМИЙН ХӨГЖИЛ ДЭВШЛИЙН ЗАМААР

Ц. БААТАР

Эртний Кампучи орныг дайн түрэмгийллийн түшин газар, түүхий эдийн хавсарга болгох гэсэн империалист гүрнүүдийн өрсөлдөөнт ноёрхол энэ нутагт 1863¹ оноос хойш ээлж дараалан солигдож, кампучийн ард түмнийг хичнээн их уй гашуу, гамшиг зовлонд учруулсныг түүх гэрчлэх билээ.

Эрх чөлөөнд дуртай кампучийн ард түмэн Империалист колоничлол, шинэ колоничлолын эсрэг удаа дараа босч тэмцсээр ирсэн түүхтэй. 1970 он буюу америкийн империалистүүдийн дуулгавартай зарц болсон Лон Нол тэргүүтэй цэргийн эрхтнүүд Кампучид төрийн эргэлт хийж АНУ-ын цэрэг Кампучид орсон тэр үеэс империалист түрэмгийлэгчдийг эсэргүүцсэн кампучийн ард түмний тэмцэл нэн хүчтэй өрнөж, эх оронч дэвшилт бүх хүчнийг тэмцэлд босгожээ. Тэмцлийн үр дүнд 1975 оны дөрөвдүгээр сард Энэтхэг-хятадын хойгт америкийн түрэмгийлэгчдийг бут цохисон явдал нь энх тайван, ардчилал, хөгжил цэцэглэлтийн саруул сайхан замаар замнах бололцоог кампучийн ард түмэнд олгож өгсөн билээ.

Гэвч Кампучийн өмнө нээгдсэн энэ таатай сайхан боломж тухайн үед ашиглагдаагүйн хамаг учир нь үндэсний эрх ашгаас урван тэрслэгч «улаан кхмерүүдийн»² харгис бүлэглэл ард түмнээ хуурч мэхлэн Кампучийн Ардын Хувьсгалт Нам (КАХН), дэвшилт бүх хүчнийг устгах замаар засгийн эрхийг булаан авсан явдал билээ. «Улаан кхмерүүдийн» удирдагчид хэмээн өөрснийгөө өргөмжилсөн Пол Пот, Иенг Сарийн харгис дээрэмчид тус орны нутаг дэвсгэрт «Мао Зэдуны үзэл санаа» гэрээслэлийг хэрэгжүүлснээр Кампучи орон уй гашуу зовлон зүдгүүрийн цусан далай болж хувирчээ.

Дөрөв хүрэхгүй жилийн дотор урван тэрслэгчдийн бүлэг, тэдний хань хамсаатнууд огтхон ч гэм буруугүй 3 сая гаруй хүн ардыг аймаглан устгасан юм.

1.1863—1953 он хүртэл Францын колоничлолд (үүнээс дэлхийн II дайны үед буюу 1935 он хүртэл Японы эзэмшилд) 1970—1975 он АНУ-ын түрэмгийлэлд, 1975—1979 он хүртэл маоизмын аймшигт туршилтанд тус тус өртөгдөж байв.

2.Энэ бүлэглэлийг гол төлөв жижиг хөрөнгөтөн, чинээлэг жижиг газар эзэмшигчдээс гаралтай Парист суралцсан хэсэг залуу 50-иад оны шувтаргаар Пномпеньд буцан ирж байгуулжээ. Уг бүлэглэлд анархист, троцкист үзлээрээ нэрд гарсан техникийн дунд боловсролтой Салот Сар (ирээдүйн Пол Пот,) дунд сургуулийн боловсролтой Иенг Сари, эдийн засгийн дээд боловсролтой Кхиеу Самфан дунд боловсролтой Тьонн, хожим нь Иенг Сари, Салот Сар нарын эхнэр болсон эгч дүү Кхиеу Тарат, Кхиеу Поннари нар оржээ. —«Проблемы Мира и социализма» 1980. № 8. с. 75.

3.Кампучийн Ардын Хувьсгалт Намын (тэр үед Кхмерийн Ардын Хувьсгалт Нам гэж нэрлэж байв) анхдугаар их хурал бүрэлдэж байв. 1951 оны хоёрдугаар сард хуралдсан ЭХКН-ын П их хурлаас бие даасан гурпан нам бий болгох шийдвэр гаргажээ.

Цуст дэглэм тогтсон анхны өдрөөс эхлэн ард олны эсэргүүцэл нэн хүчтэй өрнөв. Эсэргүүцлийн голомтууд нийт ард түмний зэвсэгт бослого болон өргөжих явц дунд 1978 оны арван хоёрдугаар сарын 2-нд Кампучийн Улс Үндэстнээ Аврах Нэгдсэн Фронт (КУУАНФ) үүсч төрлөө. (Одоо-Кампучийн Үндэсний Байгуулалт, Хамгаалалтын Нэгдмэл фронт) гэж нэрлэх болов. (Ц. Б.)

Нэгдмэл фронтын дайчид КУУАНФ-ын Намын Төв Хорооны удирдлагаар улс орондоо түүхэн ялалт байгуулсны үр дүнд ард түмний эсрэг Пол Пот, Иенг Сарийн цуст дэглэмийг түлхэн унагав. 1979 оны нэгдүгээр сарын 11-нд чөлөөлөх дайны галын дунд үүсэн байгуулагдсан Ардын Хувьсгалт Зөвлөл улс орны засгийн бүх эрхийг гартаа авч Бүгд Найрамдах Кампучи Ард Улсыг тунхагласан билээ.

Энэхүү түүхэн ялалт бол кампучийн ард түмнээс үндэсний тусгаар тогтнолынхоо төлөө америкийн империализм болон харгис бусад хүчний эсрэг явуулсан эрэлхэг зоригтой шаргуу тэмцлийн зүй ёсны үр дүн мөн байлаа.

Ийнхүү КУУАНФ-оор удирдуулсан Кампучийн эх оронч хүчин социалист хамтын нөхөрлөлийн орнууд хийгээд дэлхийн дэвшилт хүчний бүх талын дэмжлэг тусламжинд түшиглэн үндэсний эрх чөлөө тусгаар тогтнолын төлөө тэмцлийн хатуу ширүүн замыг даван туулж үнэн шударга үйл хэргийнхээ ялалтыг хангав. Ингэснээрээ БНКАУ империалист шинэ колоничлол, жанжлалын эсрэг бүх нийтийн энх тайван, олон улсын аюулгүй байдал, ардчилал, дэвшил, хөгжлийн төлөө тэмцэгч хүчний эгнээнд багтан орсон юм.

Кампучийн ард түмний энэхүү ялалт Энэтхэг-хятадын хойгийн ард түмний нэгдмэл тэмцэлд ихээхэн чухал хувь нэмэр оруулсан түүхэн үйл явдал болов.

Өнөөдөр Кампучийн ард түмэн улс орныхоо нийгэм эдийн засаг, улс төрийн бүтцийг сэргээн босгох зорилгоор шургуу хөдөлмөрлөж байна. Өнгөрсөн 1981 он кампучийн ард түмний түүхэнд ардын төрийг байгуулах үндэсний тусгаар тогтнолыг бэхжүүлэхэд онцлог тэмдэглэлтэй он боллоо. Тухайлбал тавдугаар сарын 1-нд БНКАУ-ын төрийн дээд бай-гууллага Үндэсний Хурлын бүх нийтийн сонгууль явагдсан нь Кампучийн түүхэн дэх анхны, жинхэнэ ардчилсан сонгууль байлаа. Бүх нийтийг хамарсан энэхүү сонгуулиар тус улсын төрийн эрх барих дээд байгууллагад 117 депутатыг сонгожээ.⁴ Тэдний дунд БНКАУ-ын нам төрийн удирдагчид ажилчин, тариачин, сэхээтний төлөөлөгчид өөрөөр хэлбэл шинэ залуу улсын гэрэлт ирээдүйг гардан байгуулагчид ард түмнээ төлөөлөн оролцсон байна.

Бүх нийтийн сонгууль нь БНКАУ-ын Ардын Хувьсгалт Зөвлөлийн энх тайванч гадаад бодлогыг ард түмэн бүрэн дэмжиж байгаагийн тод илэрхийлэл болов. Кампучийн ард түмний бат нэгдэл нягтралын илрэл болсон энэ бүх нийтийн сонгууль кампучийн хувьсгал эргэлт буцалтгүй гэдгийг дахин яруу тод харуулсан улс төрийн ихээхэн чухал ач холбогдолтой үйл явдал болсон юм.

Бүх нийтийн сонгуулийн дүнд байгуулагдсан засгийн эрх барих төв орон нутгийн байгууллага ард түмний хүсэл эрмэлзлэлийг жинхэнэ илэрхийлэгч байгууллага болов. Ингэснээр ардын хувьсгалт төр засгийг бэхжүүлэх зорилт хэрэгжив. Мөн кампучийн түүхэнд анхны ардчилсан үндсэн хуулийг баталлаа. Энэ үндсэн хууль тус орны ардын эрхт байгуулла-

гын ялалтыг хуульчлан бататгав. Үндсэн хуульд: «Ард түмэн улс орныхоо эзэн мөн. Ард түмэн засгийн эрх барина»⁵ гэж заажээ.

Сүүлийн хэдхэн жилийн дотор Кампучид гарсан улс төр, эдийн засгийн үндсэн өөрчлөлт нь Үндсэн хуулийн зөв зүйтэй болохыг батлан харуулсан жишээ боллоо. КАХН, БНКАУ-ын ардын хувьсгалт засаг төрийг бэхжүүлэх талаар авч явуулсан дээрх арга хэмжээний зэрэгцээ 1981 оны тавдугаар сарын сүүлчээр КАХН-ын IV их хурал хуралдаж улс орны эдийн засаг соёлыг хөгжүүлэх, кампучийн ардчилсан хувьсгалыг бататгах улс орныг социализмын замаар цаашид удирдах гол хүч марксист-ленинист намыг бэхжүүлэх намаас ойрын ирээдүйд хэрэгжүүлэх дотоод гадаад бодлогын чиглэлийг тодорхойллоо.

Пол Пот, Иенг Сари, Кхиеу. Самфан нарын хүйс тэмтрэх дэглэм улс орныг цөлмөн тонож, үндэсний мөнгөн тэмдэгийг устгаж үйлдвэрүүдийг эвдэн сүйтгэсний уршгаар тус орны эдийн засаг сүйрэлд орж, таваар мөнгөний харилцаа үгүй болсон байв. Харгис хүчний гар хөл болсон цуст дэглэмийнхэн нийгмийн бүх бүтцийг ингэж үндсээр нь устгасан учраас улс орныг дахин сэргээн босгох үйл явц асар их хүнд нөхцөлд эхэлсэн юм.

Энэ талаар Кампучийн Ардын Хувьсгалт Намын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга, Бүгд Найрамдах Кампучи Ард Улсын Төрийн зөвлөлийн дарга, Хенг Самрин «эрх чөлөөгөө олсныхоо дараа кампучи хүмүүс бидэнд зөвхөн хоосон гар л байв»⁶ гэсэн билээ. Улс орны нийгмийн амьдралын бүх бүтцийг ийнхүү шинээр эхлэх болсон хүнд хэ- цүү үед социалист хамтын нөхөрлөлийн орнууд, юуны өмнө ЗХУ, БНСВУ-ын бүх талын тусламж дэмжлэгтэйгээр кампучийн ард түмэн өөрийн амь бие хайргүй шаргуу хөдөлмөрөөрөө улс орныхоо улс төр, нийгэм-эдийн засаг соёлын амьдралыг цоо шинэ үндсэн дээр сэргээн босгох нөр их ажлыг эхэлсэн билээ.

КАХН хувьсгалт зорилтыг шийдвэрлэхдээ үндэснийхээ онцлог шинж, улс орныхоо бодит байдал, боломжийг харгалзан социализмд аажмаар шилжих замыг сонгож авсан юм.

Энэ замын ойрын ирээдүйн зорилтыг тодорхойлж КАХН-ын IV их хурлын тогтоолд: «нам ард түмэнд хамгийн гол зүйл бол үндэсний тусгаар тогтнолыг найдвартай хамгаалах, хөгжлийн социалист замд шилжих нөхцөл бий болгох явдал мөн»⁷ гэж заажээ. Үүнтэй холбогдуулан дурдахад КАХН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга БНКАУ-ын Төрийн Зөвлөлийн дарга Хенг Самрин МАХН-ын Төв Хороо БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчид, Сайд нарын Зөвлөлийн урилгаар 1981 оны арванхоёрдугаар сарын эхээр БНМАУ-д хийсэн албан ёсны найрсаг айлчлалынхаа явцад аугаа их Октябрийн хувьсгалын түүхэн ялалтын шууд нөлөөгөөр Монголд ялан мандсан ардын хувьсгалын хөгжил, ЗХУ-ын шийдвэрлэх тусламжтайгаар капитализмыг алгасан хөгжиж байгаа БНМАУ-ын хөгжил дэвшлийн түүхэн замнал, капиталист биш хөгжлийн замын туршлагатай танилцаад хэлэхдээ: «Манай ард түмэн улс үндсээ сэргээн босгохдоо танай орноос жишээ авах бөгөөд энэ үлгэр дууриалал нь бидний гэрэлт ирээдүйгээ итгэл төгс харах найдварыг бататгаж өгөх болно»⁸ гэжээ.

Социализмд аажмаар шилжих зорилтыг шийдвэрлэхэд тус орны эдийн засгийн эх салбар болсон хөдөө аж ахуйг төлөвлөгөөтэйгөөр өөрчлөн байгуулах асуудлыг нам гол зорилтоо болгон дэвшүүлэн тавив.

5. «Проблемы мира и социализма» 1981. № 11. с. 11.

6. БНКАУ-ын нам, засгийн төлөөлөгчид манай оронд албан ёсны найрсаг айлчлалт хийж байгаатай холбогдуулан хийсэн монгол, кампучийн найрамдлын цуглаан дээр хэлсэн үг. («Үнэн» 1981 оны 12-р сарын 12)

7. «Үнэн» 1981 оны 12-р сарын 8.

8. «Үнэн» 1981 оны 12-р сарын 13.

Чухамхүү энэ зорилгын үүднээс ойрын таван жилд (1981-1985) тариалангийн талбайг 2,3-2,5 сая га.д үхэр сүргийн тоо толгойг 1,4-1,5 саяд хүргэхээр төлөвлөсөн байна. Энэ зорилтыг шийдвэрлэснээр ард түмний амьдралыг сайжруулах бодит хэтийн төлөв нээгдэхээс гадна аж үйлдвэрийг түүхий эдээр хангах, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспортын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, эрэлт ихтэй барааг аль болох ихээр үйлдвэрлэж зохих хэмжээний нөөцтэй болох нөхцөл хангагдах юм.

КАХН хөдөө аж ахуйг хөгжүүлэхээр дэвшүүлсэн төлөвлөгөөт зорилгоо хэрэгжүүлэхийн тулд газар тариалан, мал аж ахуйг хослон хөгжүүлэх, атар газар эзэмших, хөдөө аж ахуйг механикжуулах, усалгааны системийг сайжруулах, тутаргын талбайг нэмэгдүүлэх, техникийн ургамлын үйлдвэрлэлийг өргөтгөх талаар системтэй арга хэмжээ авч байна.

Өнгөрсөн богино хугацаанд цагаан будааны үйлдвэрлэл 3 дахин өссөнөөр улс орныг нөмөрч байсан өлсгөлөнгийн аюулыг арилгаснаар барахгүй хоол хүнсний гол хэрэгцээг өөрийн нөөцөөр хангаж эхэллээ. Мөн зарим үйлдвэрийн үндсэн түүхийн эд болох техникийн ургамал тариалах талбайн хэмжээ нэлээд өсөв. Тухайлбал 5000-га-д каучук, 1500 гад хөвөн чихрийн нишингэ тариалах болов.⁹ 1982 онд газар тариалангийн үйлдвэрлэлээс хурааж авах ургацын хэмжээг 1,7 сая тонн-д хүргэх зорилт тавьж байна.¹⁰

Хөдөө аж ахуйг хамтын хөдөлмөрийн замд шилжүүлэх процессын эхлэл болох «үйлдвэрлэлийн харилцан туслалцах бригад» бүх тариачин өрхийн 90 гаруй хувь нь хамрагдаад байна. Одоо Кампучид 95 мянган «үйлдвэрлэлийн харилцан туслалцах бригад»¹¹ ажиллаж байна. Загасчид, гар урчуудын дотор бас ийм бүлгүүд байгуулагдаж байна.

Одоо тус улсад 100 гаруй үйлдвэрийн газар сэргээгдэн хэвийн байдлаар ажиллаж эхлэв. Эдгээрт нэхмэлийн фабрик, резинэн эдлэлийн завод, механик-засварын газар, жимс, сэрүүн ундааны завод, тамхины фабрик, цахилгаан станц, ус цэвэрлэх төхөөрөмж, хотын нийтийн аж ахуйн төв зэрэг газрууд орж байна.

Тус орон дахин өөрийн мөнгөний нэгж-риельтэй болов. (4 риель 1 америк доллартай тэнцэнэ). Мөнгөний системийг ийнхүү дахин сэргээн гүйлгээнд оруулсан явдал үйлдвэрлэлийн ба таваарын солилцооны өсөлтийг хангах, улмаар дотоодын зах зээлийн асуудлыг шийдвэрлэх, хүн амын амьдралын түвшинг дээшлүүлэхэд мэдэгдэхүйц түлхэц өгчээ.¹²

КАХН-аас улс орныхоо эдийн засгийг сэргээн босгох талаар авсан дээрх арга хэмжээний үр дүнд төв болон орон нутгийн чанартай худалдаа, аж үйлдвэр, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хамарсан улсын сектор бүрэлдэн төлөвшиж байна. Мөн үйлдвэрлэлийн харилцан туслалцах бригадыг хамарсан хоршооллын сектор өргөжиж, тариачин, гар урчуудын хувийн үндсэн дээр хөтөлдөг аж ахуйг төлөөлсөн гэрийн сектор улсын орны эдийн засгийн амьдралыг сэргээхэд нилээд тусалж байна.

Сүүлийн жилүүдэд Энэтхэг-хятадын хойгийн гурван орон хөдөө аж ахуй усжуулалт, тээвэр, бүс нутгийн хэмжээний суурь шинжилгээний талаар болон боловсон хүчин бэлтгэх салбарт эдийн засаг, шинжлэх ухаан техникийн хамтын ажиллагааны хамтарсан программ хэрэгжүүлсэн нь Кампучийн улс ардын аж ахуйг хөгжүүлэхэд их хувь нэмэр оруулж байна.

Кампучийн үндэсний эдийн засгийн хөгжилд бас нэг чухал ач холбогдолтой олон улсын байгууллагын нэг бол Меконг мөрний нөөи баял-

9. «Азия и Африка сегодня», 1982. № 1. е. 13.

10. Мөн тэнд. 12-р тал.

11. Мөн тэнд 13-р талд үзнэ үү.

12. «Эдийн засаг» 1982 оны 1-р сар. № 2.

гийг хамтран судалж ашиглах асуудал эрхэлсэн түр хороо юм. Империализм, харгис хүчний шахалт хавчилтын улмаас одоо болтол БНКАУ өөртөө шууд хамаарах уг асуудлыг шийдвэрлэхэд оролцож чадахгүй байгаа юм. Гэвч Вьетнам, Лаос, Тайланд улс бусад хэдэн орон, олон улсын байгууллагуудын төлөөлөгчид бүрэлдэхүүнд нь ордог тус түр хороонд БНКАУ-ыг элсүүлэх нь хойшлуулшгүй чухал болохыг Вьетнам, Лаос удаа дараа тэмдэглэсээр ирлээ.¹³

Өнгөрсөн хугацаанд Кампучийн ард түмэн пол потынхоос үндэсний соёл боловсрол, эрүүлийг хамгаалах салбарт учруулсан хохиролыг арилгах замд багагүй амжилт оллоо. Одоо тус улсад 6 мянга гаруй бага сургуульд сая гаруй охид хөвгүүд суралцаж байна. Багш нарын тоо 20 мянгад хүрэв.¹⁴

Соёл гэгээрэл, эрүүлийг хамгаалах, худалдаа, санхүү, тээвэр холбоо зэрэг улс ардын аж ахуйн янз бүрийн салбарт үндэсний мэргэжилтэй боловсон хүчнийг курс дугуйлангийн хэлбэрээр бэлтгэн гаргаж байна. Одоо тийм дугуйланд Кампучийн 8000 гаруй охид хөвгүүд суралцаж байна. Пномпень хотноо багшийн дээд сургууль болон эмч-эм найруулагчийн факультетууд хичээллэж эхлэв. Бүх муж болницьтай болсноор тус орны хүн ам эмнэлгийн үйлчилгээгээр хангагдах үндэс суурь тавигдав.

Үндэсний соёлын салбарт КАХН, төрөөс явуулж буй ажиллагаа нь улс орны хөгжилд асар их нөлөөлж, ард түмний дотор эх оронч үзэл, үндэсний бахархал төрүүлэн, тэднийг интернационалч ухамсраар хүмүүжүүлэхэд онцгой анхаарал тавьж байна.¹⁵

МАХН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга н. Ю.Цэдэнбал Кампучийн ард түмний богино хугацаанд олсон эдгээр ололт амжилтыг өндрөөр үнэлж хэлэхдээ: «Кампучийн ард түмний эдгээр хувьсгалт ололт нь хувьсгалын дайснуудын саад тотгор учруулах, хорлон сүйтгэх ажиллагаа, зэвсэгт халдлагын эсрэг империалист болон жанжлагч хүчний зогсоо зайгүй өдөөн хатгасан оролдлогын эсрэг тэмцэж буй маш хүнд нөхцөлд байлдан олж байгаа учраас бүр ч их ач холбогдолтой юм»¹⁶ гэсэн билээ.

БНКАУ-ын олон улсын нэр хүнд хэлбэрэлтгүй өсч байна. Өнөөдөр дэлхийн 30 гаруй улс орон, үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн БНКАУ-ыг хүлээн зөвшөөрөөд байна. Бүх улс оронтой тухайлбал хөрш зэргэлдээ орнуудтайгаа, тэгш эрх, энх тайвнаар зэрэгцэн орших үндсэн дээр харилцаагаа хөгжүүлж байна. 1979-1981 онд БНКАУ-ын дээд хэмжээний төлөөлөгчид ах дүү социалист бараг бүх оронд айлчиллаа. Эдгээр айлчлалын үеэр хийсэн хэлэлцээрүүдийн үр дүнд БНКАУ болон дээрх орнуудын эдийн засаг, соёлын талаар хамтран ажиллах гэрээ хэлэлцээрт гарын үсэг зурсан явдал дээрх орнуудаас кампучийн нийгмийн амьдралын бүх хүрээнд сэтгэл харамгүй үзүүлж байгаа интернационалч тусламж дэмжлэгийг улам бүр өргөтгөсөн юм.

1982 оны хоёрдугаар сарын 5-нд болсон ЕНКАУ-ын Үндэсний Хурлын чуулган өнгөрсөн хугацаанд улс орны нийгэм улс төр, эдийн засаг соёлын бүх салбарт кампучийн ард түмний олсон тэдгээр ололт амжилтын уг сурвалж нь ЗХУ, Вьетнам, Лаос болон ах дүү социалист бусад орнуудаас

13. «Үнэн», 1982 оны 12-р сарын 30.

14. «Азия и Африка сегодня», 1982. № 1, с. 13.

15. «Проблемы мира и социализма» 1981. , с. 13.

16. БНКАУ-ын нам, засгийн төлөөлөгчдийн БНМАУ-д айлчлах үеэр болсон Монгол, Кампучийн найрамдлын цуглаан дээр хэлсэн үг. —«Үнэн», 1981 оны 12-р сарын 12.

үзүүлж байгаа олон талт интернационалч тусламж дэмжлэгийн үр дүн юм гэж тэмдэглээд чуулганаас эдгээр оонуудтай бүх талын ажиллагаагаа улам өргөжүүлэн хөгжүүлэхийг чухалчилан заав.¹⁷

Кампучийн ард түмэн империалист шинэ колонилогчид болон харгис бусад хүчнийг аялдан дагасан АСЕАН-ны зарим орны харгис бүлгийн шахалт хавчилт үзүүлж байгаа нөхцөлд улс орноо сэргээн босгох дээрх заалтыг гаргасан нь бүр ч их ач холбогдолтой юм.

Кампучи улс социализмын үндсийг байгуулах замаар урагш итгэлтэй замнаж, амжилт олж, ардын засаг гуйвалтгүй бэхжиж байгаа нь кампучийн хувьсгалын дайснуудад хорсол занал төрүүлж байна. Дэлхийн харгис хүч олон улсын тавцанд дээр БНКАУ-ын өсөн өргөжиж байгаа нэр хүндийг хорлон бусниулж, НҮБ дахь кампучийн суудлыг пол потын алуурчид эзэлсэн хэвээр байлгахыг аль байдгаараа оролдож байна.

Тэд бас өөрсдийн дуулгавартай тоглоомын этгээдүүдийг Пномпений засгийн эрхэнд тавих гэсэн санаагаа орхиогүй хэвээр байгаа юм. Тэгээд ч Пол Пот, Лон Нол, Сон Сан, Кхиеу Самфан, Нородом Сианук-энэ хэдийг эвсэлдүүлэн нэгтгэх гэж оролдож байна. Олон жилийн турш өштөн дайсан байсан тэр хэдийг Пномпень дэх өнөөгийн засаг, төрийг үзэн яддаг үзэл л одоогоор нэгтгэж байна.

Дэлхийн харгис хүчнүүд чухамхүү тэдний энэ үзлийг ашиглаж пол потынхон болон кхмерийн гадаадад дүрвэн гарсан харгис бусад бүлгийнхний төлөөлөгчдийг турхиран 1982 оны зургадугаар сарын сүүлчээр «Ардчилсан Кампучийн эвслийн засгийн газар» гэгчийг байгуулсан тухай Куала-Лумпур (Малайз) хотноо зарласан юм. Кампучийн ард түмний үндэсний эрх ашгийг үл хайхран үйлдэж байгаа энэ хуйвалдааныг дэлхийн дэвшилт хүч нэгэн дуугаар эрс буруушааж байгаа билээ.

Нөгөө талаар АНУ тэргүүтэй дэлхийн харгис хүч АСЕАН-ы орнуудыг зөвлөлтийн эсрэг, коммунизмын эсрэг үзлээр хордуулж сэтгэл зүйн дайныг шатлан өргөжүүлж байна. Энэ нь АСЕАН-ы орнуудыг айлган сүрдүүлэх, харилцан үл итгэх уур амьсгал бий болгоход чиглэгдэж байна. Тухайлбал, «Ардчилсан Кампучийн радио» гэгч, кампучийн ард түмний бүтээн байгуулалтын ололт амжилтыг гуйвуулах, вьетнамын цэргийн хүч тайландын хилийг зөрчиж байгаа мэтээр санаанаасаа зохиосон суртал нэвтрүүлэг хийх, түүгээр ч үл барам Энэтхэг-хятадын хойгт Зөвлөлт Холбоот Улс цэргийн баазууд байгуулж байгаа мэт үл үн- дэсгүй гүтгэлэг хийсэн байна.¹⁸

Бодитойгоор үзвэл чухамхүү АНУ тэргүүтэй дэлхийн харгис хүч л Тайландад үүрлэсэн полпотчууд, зүсэн бүрийн харгис этгээдүүдэд асар их «тусламж» гэгч өглөгөө хайрлан тэднийг Тайландаас кампучийн нутаг дэвсгэр рүү уулгалан дайруулж байгаа билээ. Тэдний явуулж байгаа энэ түрэмгий ажиллагааг улам идэвхжүүлэх хэрэгтэй гэж ивээн тэтгэгчид нь шаардах болсныг Гонконгийн хэвлэлд «Өмнөд хятадаас явуулдаг ардчилсан кампучийн дуу хоолой радио станц Сон Сан, Н. Сианук нарыг Кампучийн эсрэг явуулах Сингапурын хэлэлцээрийг өргөжүүлэхэд муу ажиллаж, «Вьетнамын булаан эзлэгчдийн» стратегид туслаж байна»¹⁹ гэж зэмлэсэн тухай мэдээлжээ.

Харгис хүчний энэ мэт ил далд элдэв явууллагын талаар МАХН-ын XVIII их хурлын тайлан илтгэлд: «Ардын эрхт Кампучийн дотоод хэрэгт хөндлөнгөөс балмадаар оролцох, кампучийн ард түмний үзэн яд-

17. «Правда», 7 февраля 1982 г.

18. —«Үнэн», 1982 оны 11-р сарын 17.

19. «Фар истерн экономик ревью» 1982. № 1. , 12-р тал.

даг хүйс тэмтрэгч дэглэмийг сэргээх гэсэн оролдлогыг хаанаас ч хийлээ гэсэн бүрмөсөн балран сүйрэх тавилантай юм»²⁰ гэж тэмдэглэсэнчилэн кампучийн дайснуудын хорт явууллага нуран унасаар байна.

Кампучи улс ах дүү Вьетнам, Лаостай хамтран бүс нутгийн энх тайван тогтвортой байдлыг хангахын төлөө зайлшгүй шаардлагатай амин чухал санаачлага гаргаж, байнгын идэвхтэй хүчин чармайлт тавьж ирсний үр дүнд АСЕАН-ы орнуудтай хэвийн найрамдалт харилцаа хөгжүүлэх чиглэлд нилээд амжилт олж байна. Тухайлбал Энэтхэг-хятадын хойгийн улсууд болон АСЕАН-ы орнуудын улс төрийн зарим бүлгүүдийн хүч чармайлтын үрээр энэ хоёр хэсэг улсууд яриа хэлэлцээ хийх замд нилээд ахиц гаргаж байна. Тухайлбал, энэ зорилгоор БНСВУ, БНАААУ БНКАУ-ын Гадаад Явдлын Яамны сайд нарын хэмжээнд болсон бага хурлаас дэвшүүлсэн оновчтой саналууд нь бий болсон асуудлыг шийдвэрлэх, жинхэнэ ёсоор хамтран ажиллах, тус бүс нутагт энх тайван тогтвортой байдал бүрэлдүүлэх таатай зам нээж байгаа юм.

Ах дүү гурван орны дээрх санаачлагыг өндрөөр үнэлж нөхөр Л. И Брежнев, Ю.Цэдэнбал нар 1982 оны наймдугаар сарын Крымын нөхөрсөг уулзалтын үеэр: «Энэтхэг-хятадын хойгийн гурван орны саяхны сайн санааны үйл ажиллагааг тухайлбал, Вьетнамын цэргийн хэсгийг Бүгд Найрамдах Кампучи Ард Улсаас гаргах, АСЕАН-ы орнууд болон хятад, хөрш бусад улстай яриа хэлэлцээ хийх талаар авч байгаа оновчтой практик арга хэмжээг Зөвлөлт Холбоот Улс, Монгол Улс сэтгэл ханамжтай тэмдэглэж байна»²¹ гэсэн билээ.

Энэтхэг-хятадын хойгийн ах дүү гурван орны эдгээр оновчтой санаачлагыг дэлхийн харгис хүчнүүд жадлан эсэргүүцэж байгаа учраас энэ бүс нутаг түгшүүртэй байдлын голомт хэвээр байна.

Гэвч БНКАУ ах дүү орнуудтайгаа хамтран бүс нутагтаа энх тайван, тогтвортой байдал тогтоохын төлөө цуцалтгүй тэмцэж, зүсэн бүрийн дайсагнасан явууллагад шийдвэртэй няцаалт өгч, хувьсгалт ололтоо найдвартай хамгаалж байна.

Кампучид нэгдүгээр сарын хувьсгал ялснаар манай хоёр орон, ард түмний хооронд ах дүүгийн найрамдалт харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх өргөн боломж нээгдсэн билээ.

МАХН-ын Төв Хорооны Улс төрийн товчооны гишүүн, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дарга нөхөр Ж. Батмөнх тэргүүтэй БНМАУ-ын нам, засгийн төлөөлөгчид 1979 онд БНКАУ-д найрсгаар айлчлах үеэр гарын үсэг зурсан Монгол-Кампучийн хамтарсан тунхаглал манай хоёр орны ах дүүгийн найрамдалт харилцааны бат бэх үндэс суурийг тавьсан юм. Өнгөрсөн оны арванхоёрдугаар сарын эхээр МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчид, Сайд нарын Зөвлөлийн урилгаар КАХН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга, БНКАУ-ын төрийн зөвлөлийн дарга Хенг Самрин тэргүүтэй БНКАУ-ын нам, засгийн төлөөлөгчдийн манай оронд хийсэн айлчлалын үр дүнд найрамдал хамтын ажиллагааны тухай Гэрээ байгуулж, Монгол-Кампучийн хамтарсан мэдэгдэл гаргасан нь БНМАУ, БНКАУ-ын ах дүүгийн найрамдалт харилцаа хамтын ажиллагааг шинэ шатанд гаргав.

Улс орноо сэргээн босгох социалист нийгмийн үндсийг байгуулах, БНКАУ-ын олон улсын байр суурийг бэхжүүлэхийн төлөө Кампучийн ард түмний тэмцлийг социалист хамтын нөхөрлөлийн бусад орны хамт Бүгд Найрамдах Монгол Ард Улс тал бүрээр дэмжиж ололт амжилтанд нь баярлан бахархаж байдаг юм.

20. Ю. Цэдэнбал. Монгол Ардын Хувьсгалт Намын XVIII их хуралд тавьсан Намын Төв Хорооны тайлан ойрын жилүүдийн зорилт. УБ. , 1981 . , 11-р тал

21. «Үнэн», 1982 оны 8-р сарын 21, № 200.

КАМПУЧИЯ НА ПУТИ СОЦИАЛЬНОГО ПРОГРЕССА

(Резюме)

Победа кампучийского народа и провозглашение Народной Республики-Кампучия в январе 1970 г. явились закономерным результатом общей борьбы народов Индокитая за свободу и независимость.

Ныне народ Кампучии при всесторонней братской помощи стран социалистического содружества-самоотверженно трудится для политического и социально-экономического возрождения своей страны.

В мае 1981 г. состоялся IV съезд Народно-Революционной партии Кампучии на котором отмечала необходимость возрождения экономики и культуры страны, укрепления революционных и демократических завоеваний. Съезд подчеркнул, что партия является главной направляющей силой в деле социалистического строительства и, укрепление ее марксистско-ленинских позиций-важнейшая задача сегодняшнего дня.

Переход к плановому ведению сельского хозяйства позволил наладить сырьевое снабжение промышленности, экспорт сельскохозяйственной продукции, а также производство товаров широкого потребления. По всей стране многие промышленные предприятия нормализовали свою работу. Правительство приступило к проведению аграрной политики, коллективизации сельского хозяйства.

Реорганизация денежной системы и введение в оборот национальной валюты позволили стабилизировать товарооборот и решить некоторые проблемы внутреннего рынка. Много внимания уделяется, подготовке национальных кадров для сельского хозяйства, культуры, образования, медицины.

Растет авторитет Народной Республики Кампучии на международной арене. Сейчас Кампучия поддерживает тесные отношения с 30 странами мира и прежде всего, со странами социалистического содружества. За период 1971-1981 гг делегации Народного правительства НРК посетили с дружеским визитом почти все братские страны.

Невзирая на давление со стороны реакционных, гегемонистских сил, Кампучия совместно с СРВ и НДРЛ ведет неустанную борьбу за стабилизацию политической обстановки в Индокитае. Эти три братские страны выдвинули совместную инициативу о созыве конференции по вопросам Юго-Восточной Азии, которая нашла широкую поддержку прогрессивных сил мира.

МНР вместе с другими братскими социалистическими странами активно поддерживает борьбу кампучийского народа за возрождение своей страны, за повышение ее международного авторитета.